

STUDIA FOLCLORICA
FOLKLORE STUDIES<https://doi.org/10.5564/sf.v45i1.4818>

Tom. XLV

2024

fasc.9

Цоор уртын дууны уран холболтын
нэгэн жишээ

Соёлтын МӨНХБАЯР*

Монгол Улсын Соёл урлагийн их сургууль

Received: Jun 16, 2024

Revised: Jul 20, 2024

Accepted: Aug, 25, 2024

Хураангуй: Өгүүлэлд цоорын уртын дуунаас “Алтан арура¹” хэмээх дууг сонгон авч аман зохиол болон уран зохиолын шүлэг зүйн үүднээс задлан шинжилгээ хийжээ. Зохиогч цоорын дууны шүлгийг судалсан зүйл цөөн байгаад үндэслэн энэхүү сэдвийг сонгон авч тус дууны уран сайхны онцлогийг нээн илрүүлэхийг гол зорилгоо болгосон байна. Зорилгоо биелүүлэхийн тулд энэ дууны шүлэгт үгсийн сангаас гадна сэдэв, төрөл зүйл, шүлгийн зохиомжийг тодорхой дэс дарааллаар задлан үзэхдээ шүлгийн сүүл холбоц (rime), уран найруулгын давталт (epistrophe)-ыг гол болгон тайлбарлажээ. Тус дууны хэд хэдэн хувилбар “Аврал дээд гурван богд”, “Цогцолсон буян үр” зэрэг дууны шүлэгтэй зэрэгцүүлэн үзэж найрын дууны дотор төр, шашны ямарваа найрт дуулдаг, эв эе, амар жаргалан буюу найралдах үеийн сайхныг өгүүлсэн энх амгалан, эрх тэгш чанарыг магтан хүсэмжилсэн агуулгатай хүндэтгэлийн дуу гэж үзжээ.

Түлхүүр үг: цоор дуу, уртын дуу, дууны шүлэг, толгой холболт, сүүл холбоц, үг давталт, уртын дууны уран сайхан

* © С.Мөнхбаяр
Email: 861961489@qq.com

¹ Арура-ар үр. Арура гэдэг нь а-ги-га хэмээх төвөд гаралтай үг бөгөөд “халуун оронд ургадаг нэгэн зүйл модны үр. Дотроо ястай, ясны дотор тослог идээтэй, эхүүн амт бүхий хоёр үзүүр шөвгөр, гонзгой бөөрөнхий хэлбэртэй...7 зүйл арур бий” хэмээн доктор О.Сүбаатар “Харь хэлний толь” (Уб., 1997, х. 20). Вишнү бурхан хүрдээр дэлдсэнд нарыг залгих гэдэг Рахын толгой тасарч рашаан үсэрснээс энэ ургамал ургасан гэдэг домогтой ажээ. Өвчнийг анагаан эдгэрүүлэх, гурван гэм, долоон тамирын өвчнийг арилгах чадалтай гэж тайлбарлажээ.

One example of the artistic feature of the
rhyme of the long song “Tsoor”

MUNKHBAYAR Soyolt

Mongolian State University of Arts and Culture

Abstract: In this article, the author has selected the song ‘Altan Arura’ from the Mongolian long song “tsoor” duun and analysed it from the point of view of folk song poetry and literary poetics. The author concluded that there is little research on the poetry of the long song ‘Tsoor’ and set his main goal to reveal the artistic features of the song. To achieve this aim, apart from the vocabulary of this song, in a certain order of analysis such as, theme, genre and poetic structure of the poem and special attention is paid over the rhyme and epistrophe lyrics of this long song. The author has made a comparative analysis over several versions of the song as well as the couplets of such long songs as ‘Avral gurban chukhag bogd’ and ‘Tsogtsolson buyani urs’. The author concluded that this song was sung on any state or religious holiday, praising and wishing for peace and equality, describing the beauty of the holiday time.

Key word: Mongolian song, poetry, research, vocabulary, Altan Arura, comparative

Удиртгал

1.1. Судалгааны үндэслэл

Судлаачид цоорын дууг монгол үндэстний дууны нэгэн өвөрмөц төрөл хэмээн үзэж, гоцлол буюу хамтарч дуулах хэлбэр, зарим уртын дуу хоолойн цоороор дамжин үүссэн гэж тодорхойлсон байдаг. Түүнчлэн уртын дуу судлаач С. Баянжаргал “Монгол уртын дууны учир зүй” (2000) бүтээлдээ, цоорын дуу болон хоолойн цоор (хөөмий) нь хөөмий, уртын дууны уялдаа хөгжлийн дээд хэлбэрт хамаардаг хэмээн тэмдэглэсэн бол Э.Гэрэлт “Монгол уртын дуу жич дуулахуй” (2003) номдоо цоор дууг уртын дуу мөн гэхийн хамт:

- Том бүтэц, цогц зохиомжтой
- Өргөн цараатай, өндөр өнгөнд хатгаж дуулдаг
- Цайруулах, шургуулан дуулах арга барилтай
- Нугалаа, уран чимэглэл ихтэй
- “Зээ, жээ”-ийн эхлэлтэй, сүүлийн түрлэгтэй
- Хөг аялгуу нь займрал, солигдол ихтэй гэж тоочсон нь цоорын дууг уртын дууны нэгэн төрөл гэж үзэх үндэслэл гэж болно. Бид ч үүнтэй санал нэгтэй байгаа тул цоорын дууны шүлгийг уртын дууны шүлгийн хэв шинжид хамааруулан үзэв.

Цоорын дууг ихэвчлэн түүхэн үндэс, хэдийд, хэрхэн үүссэн болон аялгууны талаас ихэвчлэн судалж, харин үг шүлэг, ялангуяа шүлгийн уран сайхныг нээн илрүүлсэн судалгаа харьцангуй хомс юм. Тиймээс энэ өгүүллийг бичих нөхцөлийг бүрдүүлэв.

1.2. Судалгааны зорилго

Цоорын уртын дууны гол дууны нэг нь “Алтан арура” (Алтан ар үр) дуу бөгөөд түүний шүлгийн уран сайхныг нээн харуулахад оршино.

1.3. Судалгааны зорилт

1. “Алтан арура” хэмээх цоорын дууны хувилбар өргөн тархсан тул бусад хувилбартай харьцуулан үзэж гарал үүслийн асуудлын талаар өөрийн саналыг дэвшүүлэх,

2. Тус дууны шүлгийг ижил төстэй дууны шүлэгтэй харьцуулан, уртын дууны зохиомжийн онцлогийг шүлэг судлалын үүднээс судлах,

1.4. Судалгааны эх хэрэглэгдэхүүн

Цоорын уртын дууны “Алтан арура” болон “Цогцолсон буяны үр” уртын дууны шүлгийн хувилбарууд,

1.5. Судалгааны онолын чиг баримжаа, арга зүй

Ю.М.Лотманы (1972) “Анализ поэтического текста” (Яруу найргийн бичвэр) онолын удиртгал, анализ хийх цуврал арга зүй, С.Буяннэмэхийн “Утга зохиолын онолын үүд” (1936) -д тулгуурлана.

1.6. Судлагдсан байдал

БНХАУ-ын ӨМӨЗО-ы судлаач Ф.Мэргэжихийн “Хоолойн цоорын нууц” (Мэргэжих, 1985)-д анх удаа цоорын уртын дууны талаар судлан бичиж дараа нь С.Баянжаргал, Ж.Доржраа нарын хамт “Монгол дуу хөгжмийн судлал” (Мэргэжих., Доржраа., Баянжаргал., 1997) номын 1997, 2005 оны анхдугаар болон хоёр дахь хэвлэлдээ нэлээд гүнзгийрүүлжээ. Дээрх эрдэмтдээс С.Баянжаргал 2006 онд “Цоорын дуу болон хоолойн цоор/хөөмий/” хэвлүүлсэн нь цоорын уртын дууны талаах тусгайлсан судалгааны ном болно. Мөн цоорын дууны талаар эмхэтгэл түүвэр, эрдэм шинжилгээний өгүүллүүд гарсан боловч цоорын дууны шүлгийн талаар доктор З.Сарангэрэлийн нэгэн сэдэвт бүтээлд дурдсанаас өөр хамаатах бүтээл, өгүүлэл байхгүй байсаар байна. Тиймээс монгол уртын дууны шүлгийн талаар туурвил зүйн хүрээнд олон тооны бүтээл гарсантай харьцуулбал цоорын дууны шүлгийн уран сайхныг нээх харуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм. Учир нь цоорын дуу өдгөө БНХАУ-ын ӨМӨЗО-ны Авга, Авга нар хошуугаар төвлөрөн тооны хувьд 20 хүрэхгүй тоогоор үлдсэн үнэт өв билээ. Иймд бид энэ удаа цоорын дууны нэг гол дууны шүлгийн зохиомж, шүлэглэл, утга, агуулга зэрэг уран сайхны онцлогийг тодруулах юм.

2. Үндсэн хэсэг

Цоорын уртын дуу нь Авга, Авга нарын амьдрал, түүх, соёл сэтгэлгээний онцлогийг шингээн уламжилж ирсэн учраас монгол уртын дууны тогтолцоонд өөрийн гэсэн байр суурийг эзэлдэг. Энэхүү байр суурь нь монгол шүлгийн гүн гүнзгий утга санаа, уран яруу, айзам хэмнэлтэй, сонсголт чанараар илрэхийн сацуу шүлгийн өвөрмөц зохиомжтой ч холбоотой юм. Бид “Алтан арура” хэмээн найр наадмын магнай хэсэгт дуулагддаг дууны шүлгүүдээс Дорж, Улаангэрэл нарын эмхэтгэсэн “Тэнгэр газрын хүн аялгуу” эмхэтгэл дэх хувилбарыг гол болгон (Дорж., 2011, 247) төрөл зүйл, сэдэв, зохиомж, илэрхийллийн арга хэрэгсэл, үзэл санаа, хувийн сэтгэгдэл гэсэн параметрээр авч үзэх боловч шүлгийн ерөнхий бүтэц тогтолцоог тодотгох холбоцод гол анхаарлаа чиглүүлж, ижил төстэй зохимжтой уртын дууны шүлгүүдтэй харьцуулав.

“Алтан арура” дууны шүлгийг хэзээ, хэн, юуны учир зохиосон түүх, домог байхгүй. *Төрөл зүйл* (жанр)-ийн хувьд уянгын бөгөөд магтаал, сургаалын шинжит, аж байдлын дуунд хамаарна. Аялгууны хувьд энгийн боловч хэмнэл тэгш, түрлэг бүхий бадагласан бүтэцтэй, уянгын өгүүлэмжтэй тул эгшиглэнтэй сонсогдоно.

“Алтан арура” дууны *сэдэв* нь хэн нэгэн хүн бусдад хандаж өөрийн таньж мэдсэнээ уран сайхнаар илэрхийлж байгаа мэт, магтаал болон сургаалын шүлгийн аль алиныг шинжийг хадгалсан байгаа нь анхаарал татна.

Шүлгийн аяс нь бүхэлдээ өөдрөг, гэгээлэг, амьдрал дахь сайн сайхан бүхнийг илэрхийлжээ. Энэ бүхнийг ар үр, зандан хэмээх ургамал, эцэг эх, мал сүрэг, хүн ба залуус, төр, олон түмэн гэсэн ойлголтын хүрээнд тэдэнтэй уялдан гарч ирэх сайхан гэж болох ойлголтыг гүн ухааны үүднээс шүүн өгүүлжээ.

“Алтан арура” дууны *зохиомж (байгууламж)* нь хос мөрөөр 4 түрлэгээр зохиомжлогдсон нь,

1. Алтан арурагийн амт нь сайхан
Ачит аав ээжийн сургаал нь сайхан
Түрлэг
2. Аливаа мал сүргийн шим нь сайхан
Агаруу² зандны үнэр нь сайхан
Түрлэг
3. Заяатай хүний нагац нь сайхан
Залуу хүмүүсийн наадах нь сайхан
Түрлэг
4. Төрийн дундаа түшмэд сайхан
Төрсөн олноороо найртай сайхан
Түрлэг

² Агар нь самгарди хэлний агам гэсэн утгатай үгнээс үүсэлтэй, цэцэглэдэг, үнэр төгс, мөнх ногоон мод бол зандан нь мөн самгарди хэлний sandana хэмээх үгнээс үүсэлтэй, анхилам үнэрт мод бөгөөд цагаан, улаан, хүрэн гэж ялгагддаг байна. Зонхов бурхан эхээс төрөхөд ихсийг нь булсан газраас ургасан гэж домоглодог.

Хэдийгээр эхнээсээ төгсгөл хүртэл тодорхой утгат хэсгүүдэд хуваагдахгүй, тэгш чанартай ч эхний хоёр бадагт арура хэмээх ургамлын **амтыг**, ачит аав, ээжийн **сургаалтай**, малын **шимийг** агар зандны **үнэртэй** адилтгасан байдалтай бол дараах хоёр бадагт “хүний эх-нагац” ба залуусын наадам, “хаан төрд үнэнч, зүтгэлтэй, номын дагуу үйлсийг бүтээгч төрийн түшмэл” ба олны эв найр гэсэн ойлголтыг учир шалтгаан, уялдаа холбоогоор нь эн тэнцүүлэн өгүүлсэн мэт. Дээрх адилтгалаас **Алтан арура-Ачит аав ээж, арурагийн амт-аав ээжийн сургаал**-ыг адилтгаж байгаа нь “үгийн үндсэн утгыг хэрэглэлгүй, өөр төсөөтэй үзэгдлийг тэмдэглэхэд утгыг шилжүүлэн хэрэглэснийг адилтгал гэнэ. Адилтгал бол далд зүйрлэл мөн бөгөөд хоёр үзэгдлийн төстэй байдлыг харгалзан үгийн утгыг шилжүүлэн хэрэглэх ёс мөн” (Гаадамба, 1989, 131) гэсэнтэй дүйж байна.


Мөн дууны бадаг бүрийн дараа түрлэгтэй бөгөөд мөр бүрийн төгсгөлд сайхан гэх үгийг давтсан нь бичвэрийн хөгжимлөг чанарын нэмэгдүүлжээ.

“Алтан арура” дууны *хэмнэл, холбоц* -ийн хувьд, шүлгийн үеийг кирилл үсгийн бичлэгээр бус харин монгол бичгийн бичлэгийн хэлбэрээр тооцоолдог. Үүнээс харахад шүлгийн үе, богино болон уртатгал үеийн тоо үндсэндээ жигд тэнцүү байна. Богино үеийг U, урт үеийг – тэмдэглэгээгээр тэмдэглэдэг журмыг баримтлав. Бид тэмдгээр “нь” нөхцөлийг тэмдэглэв.

- I. UU UU – UU – | U – U (12 үе)
- II. UU U UU – UU – | U – U (12 үе)
- III. UU U UU – UU – | U – U (11 үе)
- IV. UU UU – UU – | U – U (11 үе)
- V. U – U – U UU UU – | U – U (13 үе)
- VI. UU UU – UU UU – | U – U (13 үе)

Үеийн тоо хос мөр бүрд ижил тэнцүү мөртөө, нэг нэг үеэр нэмэгдсэн байдлаар зохиогдсон нь анхаарал татна.

Шүлэг А, 3, Т авиагаар эхэлсэн үсгээр толгой холбосны зэрэгцээ САЙХАН гэх үгээр сүүл холбожээ. Мөн эхний 4 хос мөрт UU – (анapest) хэмжээтэй дундын холбоос байгаа нь дууны шүлгийг илүү хэмнэлтэй болгожээ.



Ер нь дууны шүлгийн хос мөртүүд гурав дахь үедээ урт буюу өргөлттэй байгаа бөгөөд энэ нь хоёр хэлбэртэй байна. Үүнд,

- А) аругаГИЙН, ээжийН, сүргИЙН, зандны, хүнИЙ, хүмүүсИЙН гэсэн харьяалахын тийн ялгалын нөхцөлүүд,
- Б) бүлэг нь-дундАА, олноорОО гэж хамаатуулахын тийн ялгалаар дундын холбоосоос бүрдсэн байна.

Үүнээс үзвэл шүлгийн бичвэрээр тус дууны шүлгийн өргөлт (уртатгалтай үе) үгийн төгсгөлдөө байгаа ба дуулахуй үетэй харьцуулбал эдгээр холбоос өргөгдөж, төгсгөлийн сүүл холболтын **сайхан** гэдэг үг өргөлтийн хувьд буурч сонсогдож байна. Үүнийг бид сайхан гэх үгийг олон давтаж байгаагаас түүнд өргөлт авах шаардлага бага байсан бололтой гэж үзлээ.

Энэ дууны шүлгийн гол онцлог бол сүүл холбоц юм. Сүүл холбоцыг шүлэг зүйн судалгааны бүтээлүүдэд хормой холбох (Д.Цэнд), сүүл ижилсүүлэх, сүүл тохируулах (С.Буяннэмэх) гэхээс гадна найруулга зүйн аргын хувьд адаг давталт (Ш.Гаадамба) гэсэн ойлголттой холбогдоно.

С.Буяннэмэх “Холбоо найруулгын дээд толгойг тохируулах төдийгөөр зогсох бус, доорд хормойг мөн тохируулж бичих нь хамгийн гоё бөгөөд уран сайхан чимэгтэй болдог болой. ‘Юуг хормой тохируулах’ хэмээмүй хэмээж асууваас мөр бүхний эцсийн үг нь адил дахин дахин өгүүлсэн дагавруудтай бичихийг өгүүлмүй” (Буяннэмэх, 2023, 650-651) хэмээгээд шүлэг, холбооны сүүл тохируулахыг хамгийн чухал чадвар гэж үзсэн байдаг.

Найруулга зүйн хувьд “Уран давталтын дотор мөр, өгүүлбэрийн эцсийн үгийг давтах” (Ш.Гаадамба) нь зохиолын хэлний уран яруу дүрслэх илтгэх хэрэглүүрийн нэг уран зохиолын хэлний уран маяг юм. Үүнийг *epiphora* гэх бөгөөд утгыг онцлон тэмдэглэх эсвэл сэтгэл хөдлөлийн өнгийг сайжруулах зорилгоор шүлгийн зэргэлдээ хэсгүүдийн төгсгөлийн хэлний нэгжүүдийг (авиа, үг, хэл зүйн хэлбэр) давтах уран сайхны нэг арга юм. Жишээ болгож буй “Алтан арура” шүлгийн бүтэц үгсийн сангийн буюу үг давталтаар бүтсэн сүүл холбоц юм.

Ийм сүүл холбоц аман зохиол, түүний дотор Ертөнцийн гурав-ын хэвшмэл загвар юм. Тухайлбал, Ертөнцийн гурван сайхан-ыг

Жигдэрсэн оддын дунд сар сайхан

Жигүүртэн шувуудын дунд тогос сайхан

Жигдэлсэн моддын дунд галбарбаасан сайхан (Монгол ардын аман зохиолын дээж бичиг, 1978\2021: 13)

гэх мэтээр олон хувилбараар өгүүлсэн байдаг. Тиймээс судлаач Г.Галбаяр “Монгол шүлгийн сүүлийг тогтвортой холбо ёс эртний аман зохиолын олон төрлүүд төдийгүй эрт эдүгээгийн бичгийн яруу найрагт ч тогтвортой хадгалагдан ирсэн байна. Энэ нь сүүл холбоц шүлгийн айзам хэмнэлийг зангидан, утга агуулгыг яруу тодорхой илэрхийлэх үүднээс урган гардаг тогтвортой зүйл болохыг харуулж байна” (Галбаяр, 2011, Том XXXIII (359): 90) гэжээ. Үнэхээр монгол уртын дуунд “Алтан арура” цоорын дууны хувилбар, хэв маягтай адил тийм шүлгүүд цөөнгүй бий. Тухайлбал, уртын дууны “Зүйл

зүйлийн олон дууны дэвтэр” хэмээн нэгэн гар бичмэлд буй “Алтан ар үрийн амт” дууны бичвэр нь эхлэл, төгсгөл бүрэн, сайхан хэмээх үгээр чанд холбосон байдаг.

Алтан ар үрийн амт нь сайхан
Ачтай аав, ээжийн сургаал нь сайхан
Зандан модны навч нь сайхан
Заяатай аав ээжийн сургаал нь сайхан
Бурхан шажныг хүндэлбэл сайхан
Буянтай үйлийг сэдвэл сайхан
Цуглаж хурах хурал нь сайхан
Хурлын дундаас лам нь сайхан
Хувраг хүний санваар нь сайхан
Хаан хүний хууль нь сайхан
Зөөж буувал зүлэг нь сайхан
Зөвшиж ханилбал нөхөд нь сайхан
Эргэж буувал ээж нь сайхан
Эргэцүүлж бодвол ач нь сайхан
Төрийн дундаас төрөл нь сайхан
Төрлийн дундаас ноён нь сайхан
Арван цагаан бат шүлгийг
Их багаар сонсьё, бид
Далай ламын адисаар
Даяараа хамтаар цэнгэн жаргая (Алимаа, 2003, II: 390)

гэж байхад, “Аврал дээд гурван богд”, “Цогцолсон буян үр” хэмээх дуу иймэрхүү зохиомжтойн дээр хувилбар олонтой. Харамсалтай нь тэдгээрийн аялгуу мартагдаж, шүлгүүд нь үлдсэн байна.

“Аврал дээд гурван богд” (Монгол дуу судлалын товч тойм, 1975: 219)	“Цогцолсон буян үр” (Монгол дуу судлалын товч тойм, 1975: 216-217)
...Завилан суугч лам нь сайхан Жанжлан суугч ноёд нь сайхан Захиран суугч түшмэл нь сайхан Үелэн сууваас үедээ сайхан Хөхөө шувууны дуу нь сайхан Хөгжөөн тавьсан ятгын магнай (эгшиг сайхан) Гаа гаврын үнэр сайхан Галшаа бумбын рашаан сайхан...	...энэ хойтыг байцагч өвөл, зуны хур мэт Зэргийн сайхан энх амар Жаргалангийн билэг Энэ дууны аяс мэт эвтэй нь сайхан Найралцахын үест сайхан жаргах Навч цэцгийн үрс мэт сайхан Нягт шинэ жилийн билиг Наран, сарны гэрэл мэт гэгээн сайхан Тэмцлийг арилгагч Тэнгэрийн эзэн засаг мэт хурц нь сайхан Тэтгэн хүртэхийн хишиг Тэгш цагийн хур мэт цогтой нь сайхан

гэсэн жишээнүүд бол уртын дууны бичмэл хувилбарууд болно. Бидэнд Данийн нэрт аялагч, Атрофологич, дуу судлаач Хеннинг Хаслунд-Крестенсен (1896-

1948)-ний цуглуулгад буй 1936-1937 оны дуу авианы бичлэгийн төхөөрөмжид шингээсэн дуу хөгжмийн зүйлд 43 гэсэн дугаартай “Цогцолсон буяны үр” дууны нэгэн хувилбар буй.

Цогцолсон буян үрс нь
Цогт сүмбэр уул мэт бат сайхан
Чухам эрхэм сэтгэл дэх чанар нь
Цогц биеийн санааны амар сайхан
Учир лугаа зохилдох бодлого нь
Улс, түүний төр мэт бат сайхан
Утга лугаа зохиолдохын бэлгэс (буй бичлэг) нь
Олом үгүй далай мэт уужим сайхан
Нарийн нягт шинжлэх бодлого нь
Наран, сарны мандал мэт гэгээн сайхан
Найралдах үеийн сайхан жаргал нь
Навчин цэцэгсийн үрс мэт дэлгэр сайхан
Дэлсул бүхнийг арилахын цааз нь
Дээдсийн засаг мэт хурц сайхан
Дэнслүүлэн хүртэхүйн хишиг нь
Тэгш цагийн хур мэт цогтой сайхан
Улсын тотгор арилгахын цааз нь
Уридас засаг мэт хурц сайхан
Уламжлан хүртэхүйн хишиг нь
Огоот барагдаш үгүй хурц сайхан...(Сарангэрэл, 2018: 186-187)

гэсэн үгтэй аман хувилбар нь “Монгол дуу судлалын товч тойм” -д буй “Монгол дуун бичмэл дэвтэр”-т буй “Цогцолсон буяны үрс” шүлэгтэй яв цав нийлнэ. Эндээс бичмэл болон аман хувилбарт зөрөө тун бага бол цоор дууны шүлэг хамгийн хураангуй, өмнөх ба төгсгөлийн хэсгийг үлдээн гол хэсгийг дуулдаг болохыг харуулж байна.

Дууны агуулга-ыг ийнхүү олон хувилбараар тогтоож болох бөгөөд ингэж үзвэл “Алтан арура” нь найрын дууны дотор төр, шашны ямарваа найрт дуулдаг хүндэтгэлийн дуу ажээ. Өөрөөр хэлбэл, цоорын дуунд эцэг эхийн сэдэв голлох маягтай бол бусад хувилбарт улс, төр, хууль цааз, хаан, түшмэлийн эн тэгш хандах чанарыг голлох ажээ. Харин бүх хувилбарт эв эе, амар жаргалан буюу найралдах үеийн сайхныг өгүүлсэн энх амгалан, эрх тэгш чанарыг магтан хүсэмжилсэн агуулгатай байна.

Дүгнэлт

“Алтан арура” дууны бичвэрийн 61% нь нэр үг, тэмдэг нэр 35%, 1%-ийг үйл үг, үлдэх хувийг бусад үгсийн аймаг эзэлж байгаагаас тэмдэг нэр голлох байртай байгаа бөгөөд үйл үг цөөн байгаа нь тус дуу эртний монгол шүлгийн шинжийг агуулсан байхаас гадна бодит дүрслэлийг гол болгосныг харуулна. Гэсэн ч адилтгаж буй мэт ч адил юмсыг төлөөлүүлэн зүйрлэж гүн утга агуулгыг уран сайхнаар өгүүлжээ. Аристотель сүүл давталтыг адилтгал, зүйрлэлтэй

холбон үзэж байсан бөгөөд “Сайн зүйрлэл зохиох нь ижил төстэй байдлыг анзаарах гэсэн үг юм” гэж бичсэн бий (Поэтика, 1459а). Энэ санааг Ф.Уилрайт “Метафор ба бодит байдал” номдоо нарийсган шүлгийн сүүл давталт адилтгал, зүйрлэл алин болохыг ялгах хэрэгтэй гээд ойр бус хол зүйлсийг адилтгадаг гэсэн байдаг. Энэ нь тус шүлэгт үндсэндээ илэрч байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Тус шүлэгт монгол яруу найргийн хүний таван мэдрэхүйд хүртэгдэх байдлаар шүлэг зохих аргыг төгс биш боловч, ашиглаж байсан жишээ болно. Шүлэгт, арура жимсний -амт, агар зандны -үнэр, наадах-хүрэлцэх, сонсох гэх мэт.

Шүлэг нь сүүл холбоц буюу уран найруулгын давтах аргыг оновчтой хэрэглэсэн жишээ болж байна. Түүнчлэн үгийн санг авч үзвэл, Монгол хэлэнд орж ирсэн үгс-арура, агар, зандан гэх мэт үгс, мэдээлэл агуулдаггүй ч түгээмэл хэрэглэгддэг “нь” хэмээх ялгах нөхцөл 6 удаа буюу нийт бичвэрийн 15%-ийг эзэлж байгаа ч шүлгийг хэмнэлжүүлэн, айзмын багана үүсгэжээ. Харин дуунд “аливаа малынх нь (ээ) шим ману ...” гэж дуулж байгаа тул дуулах үеийн болон бичвэрийн үеийн тоо харилцан адилгүй бөгөөд шүлэг зүйн анализаас тусдаа асуудал болно. Шүлгийн хэмжээ, үе хэмнэлээ тодорхойлохоос гадна өргөлтөд үе чухал нөлөөтэй. Үүгээр авч үзвэл, өргөлтөд үе харьцангуй, үеийн байдлыг тодорхойлбол, чанга үе 15, сул үе 44 байгаагаас үзвэл шүлгийн дийлэнхийг сул үе бүрдүүлж байна. Энэ үзүүлэлт уртын дууны хувьд төдийлөн нөлөөлдөггүй түгээмэл үзэгдэл юм.

Ном зүй

А.Монгол хэлээр:

- Алимаа, А.** (2003). *Монгол уртын дууны бичмэл цоморлиг*, Боть 1-2. Улаанбаатар: Жинст харгана ХХК.
- Буяннэмэх, С.** (2017, 2023). *Сономбалжирын Буяннэмэх*, Дөтгөөр боть. Эмхэтгэж нягталж хэвлэлд бэлтгэсэн Д.Цэдэв, Ван Мандуга. Улаанбаатар:
- Гаадамба Ш., Цэрэнсодном Д.** (1978). *Монгол ардын аман зохиолын дээж бичиг* (Их дээд сургуулийн монгол хэлний ангид үзнэ). Улаанбаатар: Цагаан бамбарууш хэвлэлийн газрын цахим хэвлэл. 2021
- Гаадамба, Ш.** (1989). *Утга зохиолын онолын үндэс*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Галбаяр, Г.** (2011). *Монгол шүлгийн сүүл холбоцын зарим онцлог*. МУИС, Монгол хэл соёлын сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг. Том XXXIII (359). х.80-93
- Дорж., Улаангэрэл** (2011). *Тэнгэр газрын хүн аялгуу*. Эмхэтгэл. Өвөр Монголын хэвлэлийн бүлэглэл. ӨМХХ

Сарангэрэл., Төлүмж, (2018). *Хеннинг, Хаслундын цуглуулсан монгол ардын дууны судлал*. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо.

Б.Гадаад хэлээр:

Аристотель. (1921). *Поэтика*. Ленинград., aristotel_poetika_academia_1927__ocr.pdf



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.